



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА  
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ховд аймгийн Мөнххайрхан сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2023/145/НА/-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Ховд хот  
2023 он

Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар  
Утас: 70433061  
Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn  
Аудитын менежер: А.Цэцэгсүрэн  
Утас:70432545  
Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn  
Гэрэлт Хөхийн тэнцвэр Аудит ХХК-ны Ховд дахь салбар  
Аудитор: Д.Хишгээ  
Утас: 70432545  
цахим хаяг: hishgee.da @ gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

<b>1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....</b>	<b>3</b>
<b>2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН .....</b>	<b>5</b>
<b>3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....</b>	<b>10</b>
<b>4. АУДИТЫН ТАЙЛАН .....</b>	<b>13</b>
<b>4.1 Ерөнхий зүйл .....</b>	<b>13</b>
<b>4.2 Материаллаг байдал.....</b>	<b>14</b>
<b>4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....</b>	<b>14</b>
<b>4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ...</b>	<b>14</b>
<b>4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....</b>	<b>14</b>
<b>4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....</b>	<b>15</b>
<b>4.5.1 Завсрын аудитын талаар .....</b>	<b>15</b>
<b>4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй.....</b>	<b>15</b>
<b>5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....</b>	<b>15</b>
<b>5.3 Зөвлөмж.....</b>	<b>15</b>
<b>6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....</b>	<b>16</b>

#### **Товчилсонүгийнжагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



**ХОВД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**  
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд  
Утас: 976-70433061, Факс: 976-70433061  
E-mail: khovd@audit.gov.mn

2023.02.08 № 02/15  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-Т

**ХОВД АЙМГИЙН МӨНХХАЙРХАН  
СУМЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН  
ЭРХЛЭГЧ У.ДОЛГОРСҮРЭН ТАНАА**

#### **Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Ховд аймгийн Мөнххайрхан сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### **Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### **Асуудлыг онцолсон хэсэг**

Боловсролын салбар төсвийн шинэчлэлийн хүрээнд сургуулийн санхүүгийн эрх мэдэл, хувьсах зардал, сургуулийн бүтэц, хэв шинжийн шинэчлэл, сургалтын чанарт суурилсан цалин урамшууллын тогтолцоог бий болгосон байна.

Багш нарын цалинг ТҮ5 ангиллаар олгосон, Хувьсах зардлын тухайд багшийн эрүүл мэндийн үйлчилгээ, дата хэрэглээний зардал, хичээл практикийн зардал, багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийн зардлыг тусгаж, үүнийг хэрхэн төлөвлөх, зарцуулах аргачлалыг Засгийн газрын 2022 оны 3 дугаар сарын 2-ны өдрийн 91 дугаар тогтоолоор баталж мөрдсөн байна.

#### **Аудитын гол асуудал**

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

### **Бусад асуудлын хэсэг**

БШУСайдын 2022 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн А/500 тоот тушаалын дагуу сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, суралцагчийн хөгжил хамгаалал, багш ажилтны тасралтгүй хөгжлийг дэмжсэн үйл ажиллагаа, сургалтын орчин бүрдүүлэлт, удирдлагын манлайлал, менежмент, сургалтын байгууллагын талаархи хэрэглэгчийн сэтгэл ханамж гэсэн 6 шалгуур үзүүлэлтээр хөндлөнгийн үнэлгээ хийхэд тус Хүүхдийн цэцэрлэг онооны жингээр V түвшинд үнэлэгдсэн байна.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.БОЛДБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>40,726,543.00</u></b>	<b><u>55,773,875.12</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	-	2,140,677.38
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	-	2,140,677.38
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	-	2,140,677.38
31211	Төрийн сангийн харилцах	-	2,140,677.38
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	-	665,029.74
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	665,029.74
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	40,726,543.00	52,968,168.00
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	319,300.00	79,300.00
35130	Эм боох материал	319,300.00	79,300.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	40,407,243.00	52,888,868.00
35410	Бичиг хэргийн материал	290,000.00	13,500.00
35420	Аж ахуйн материал	2,300,002.00	2,739,702.00
35440	Түлш, шатах тослох материал	539,920.00	669,920.00
35450	Барилгын засварын материал	204,000.00	-
35460	Хүнсний материал	7,372,795.00	15,256,020.00
35470	Бусад хангамжийн материал	29,700,526.00	34,209,726.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>372,333,687.02</u></b>	<b><u>372,262,902.57</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	372,333,687.02	372,262,902.57
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	364,325,187.02	364,368,652.65
39201	Барилга, байгууламж, орон сууц	346,604,440.00	366,604,440.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(36,589,756.73)	(54,121,540.37)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	41,108,140.00	41,678,140.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(24,212,579.25)	(29,332,512.37)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	30,945,985.00	36,692,521.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(13,579,431.00)	(15,805,055.41)
39214	Бусад үндсэн хөрөнгө	21,159,875.00	21,159,875.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(5,218,062.00)	(6,663,791.20)
39217	Ном	4,106,576.00	4,156,576.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	8,008,500.00	7,894,249.92
39301	Програм хангамж	557,000.00	557,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(328,500.00)	(442,750.08)
39303	Бусад биет бус хөрөнгө	7,780,000.00	7,780,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>413,060,230.02</u></b>	<b><u>428,036,777.69</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>1,968,161.00</u></b>	<b>-</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	1,968,161.00	-
<b>413</b>	<b>Өглөг</b>	1,968,161.00	-
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	1,968,161.00	-
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>411,092,069.02</u></b>	<b><u>428,036,777.69</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	411,092,069.02	428,036,777.69
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	117,259,834.00	117,259,834.00
51101	Өмч: - төрийн	117,259,834.00	117,259,834.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	176,143,231.75	193,087,940.42
51210	Өмнөх үеийн үр дүн	176,143,231.75	176,143,231.75
51220	Тайлант үеийн үр дүн	-	16,944,708.67
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	117,689,003.27	117,689,003.27
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>413,060,230.02</u></b>	<b><u>428,036,777.69</u></b>

## 2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>270,264,622.00</b>	<b>370,660,036.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>250,385,700.00</b>	<b>28,266,636.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	555,100.00	28,266,636.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	555,100.00	28,266,636.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	555,100.00	28,266,636.00
<b>123</b>	<b>Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг</b>	249,830,600.00	-
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	249,830,600.00	-
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>19,878,922.00</b>	<b>342,393,400.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	-	294,958,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	294,958,000.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	9,464,322.00	-
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	460,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,004,322.00	-
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	10,414,600.00	47,435,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	10,414,600.00	47,435,400.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>290,218,260.73</b>	<b>353,715,327.33</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>290,218,260.73</b>	<b>353,715,327.33</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	270,990,837.77	353,715,327.33
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	187,426,733.69	235,618,291.10
210101	Үндсэн цалин	126,855,504.69	175,806,884.84
210102	Нэмэгдэл	48,297,388.00	51,438,683.02
210104	Урамшуулал	12,273,841.00	8,372,723.24
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	24,686,449.72	26,853,549.78
210201	Тэтгэврийн даатгал	16,509,528.91	18,198,572.78
210202	Тэтгэмжийн даатгал	1,871,427.41	2,255,927.98
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,248,798.44	1,804,742.05
210204	Ажилгүйдлийн даатгал	365,042.12	410,151.83
210205	Эрүүл мэндийн даатгал	3,691,652.84	4,184,155.14
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	13,245,800.00	30,846,941.00
210301	Гэрэл, цахилгаан	1,964,600.00	3,633,000.00
210302	Түлш, халаалт	10,881,200.00	26,813,941.00
210303	Цэвэр, бохир ус	400,000.00	400,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	2,003,480.00	-
210401	Бичиг хэрэг	247,300.00	-
210402	Тээвэр, шатахуун	646,960.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	57,100.00	-
210404	Ном, хэвлэл	60,000.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	155,770.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	247,000.00	-
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	589,350.00	-
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	13,088,475.00	27,024,625.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,481,800.00	240,000.00
210502	Хоол, хүнс	11,206,175.00	26,784,625.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	400,500.00	-

<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	2,880,500.00	-
210604	Урсгал засвар	2,880,500.00	-
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	71,900.00	-
210702	Дотоод албан томилолт	71,900.00	-
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	467,600.00	592,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	143,600.00	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	592,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	27,119,899.36	32,779,920.45
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,221,000.00	4,607,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,956,840.00	1,735,100.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	23,942,059.36	26,437,320.45
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>(19,953,638.73)</b>	<b>16,944,708.67</b>

### 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	117,259,834.0	117,689,003.3	176,143,231.8	411,092,069.0
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	117,259,834.0	117,689,003.3	176,143,231.8	411,092,069.0
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	16,944,708.7	16,944,708.7
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	117,259,834.0	117,689,003.3	193,087,940.4	428,036,777.7
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	117,259,834.0	117,689,003.3	193,087,940.4	428,036,777.7
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	117,259,834.0	117,689,003.3	193,087,940.4	428,036,777.7
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	16,944,708.7	16,944,708.7
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	117,259,834.0	117,689,003.3	210,032,649.1	444,981,486.4

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>269,709,522.00</b>	<b>342,393,400.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>249,830,600.00</b>	-
<b>123</b>	<b>Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг</b>	249,830,600.00	-
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	249,830,600.00	-
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>19,878,922.00</b>	<b>342,393,400.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	-	294,958,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	294,958,000.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	9,464,322.00	-
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	460,000.00	-

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,004,322.00	-
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	10,414,600.00	47,435,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	10,414,600.00	47,435,400.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>269,709,522.00</b>	<b>340,252,722.62</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>269,709,522.00</b>	<b>340,252,722.62</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>250,482,099.04</b>	<b>340,252,722.62</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	186,876,339.65	230,342,282.23
210101	Үндсэн цалин	125,858,822.74	169,291,861.77
210102	Нэмэгдэл	48,743,678.00	52,677,697.22
210104	Урамшуулал	12,273,838.91	8,372,723.24
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	23,320,439.39	32,147,399.39
210201	Тэтгэврийн даатгал	15,323,213.40	22,097,700.39
210202	Тэтгэмжийн даатгал	1,899,883.63	2,485,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,953,409.36	2,037,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	373,976.03	502,599.10
210205	Эрүүл мэндийн даатгал	3,769,956.97	5,024,499.90
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	9,064,600.00	31,216,941.00
210301	Гэрэл, цахилгаан	1,964,600.00	3,633,000.00
210302	Түлш, халаалт	6,700,000.00	27,183,941.00
210303	Цэвэр, бохир ус	400,000.00	400,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	1,745,270.00	-
210401	Бичиг хэрэг	69,400.00	-
210402	Тээвэр, шатахуун	568,900.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	57,100.00	-
210404	Ном, хэвлэл	39,600.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	423,770.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	586,500.00	-
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	14,374,150.00	36,299,100.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	391,900.00	-
210502	Хоол, хүнс	13,586,050.00	36,299,100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	396,200.00	-
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,350,000.00	150,000.00
210604	Урсгал засвар	1,350,000.00	150,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	71,900.00	-
210702	Дотоод албан томилолт	71,900.00	-
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	467,600.00	592,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	143,600.00	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	592,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	13,211,800.00	9,505,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,000,000.00	6,889,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,211,800.00	2,615,200.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>19,227,422.96</b>	-
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	8,580,552.00	-
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	8,580,552.00	-
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	10,646,870.96	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,646,870.96	-
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	-	<b>2,140,677.38</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	-	2,140,677.38
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний</b>	-	-

	үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	2,140,677.38

## 2.5 Төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>1</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	342,393,400.0	340,252,722.6
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	342,393,400.0	340,252,722.6
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	342,393,400.0	340,252,722.6
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	231,766,900.0	230,342,282.2
210101	Үндсэн цалин	188,372,300.0	169,291,861.8
210102	Нэмэгдэл	39,489,700.0	52,677,697.2
210104	Урамшуулал	3,904,900.0	8,372,723.2
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	32,147,400.0	32,147,399.4
210201	Тэтгэврийн даатгал	22,906,200.0	22,097,700.4
210202	Тэтгэмжийн даатгал	2,310,400.0	2,485,300.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,848,300.0	2,037,300.0
210204	Ажилгүйдлийн даатгал	462,100.0	502,599.1
210205	Эрүүл мэндийн даатгал	4,620,400.0	5,024,499.9
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	31,933,000.0	31,216,941.0
210301	Гэрэл, цахилгаан	3,633,000.0	3,633,000.0
210302	Түлш, халаалт	27,900,000.0	27,183,941.0
210303	Цэвэр, бохир ус	400,000.0	400,000.0
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	36,299,100.0	36,299,100.0
210502	Хоол, хүнс	36,299,100.0	36,299,100.0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	-	150,000.0
210604	Урсгал засвар	-	150,000.0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	592,000.0	592,000.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	592,000.0	592,000.0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	9,655,000.0	9,505,000.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,625,000.0	6,889,800.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,030,000.0	2,615,200.0

	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	342,393,400.0	342,393,400.0
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	294,958,000.0	294,958,000.0
131001	Улсын төсвөөс санхүүжих	294,958,000.0	294,958,000.0
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	47,435,400.0	47,435,400.0
132001	Орон нутгийн төсвөөс	47,435,400.0	47,435,400.0
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		<b>2,140,677.4</b>
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	16.0	16.0
620001	Удирдах ажилтан	1.0	1.0
620002	Гүйцэтгэх ажилтан	10.0	10.0
620003	Үйлчлэх ажилтан	5.0	5.0

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Хүүхдийн нийгэм сэтгэл зүй танин мэдэхүйн хөгжлийг дэмжих, сургалт үйл ажиллагааг чанар үр дүнтэй зохион байгуулах үндсэн зорилготойгоор Мөнххайрхан сумын сургуулийн өмнөх боловсрол олгох 112 хүүхэд, хувилбарт 23 хүүхдийг хамруулсан байна.

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Хөдөлмөрийн тухай, Боловсролын тухай, сургуулийн өмнөх боловсролын тухай, Төрийн албаны тухай, Төсвийн тухай багц, Төрийн хэмнэлтийн тухай, Шилэн дансны тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Бусад хууль тогтоомжуудын хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон. Үүнд:

Хувьсах зардлын дундаж норматив, аргачлал батлах тухай 91 дугаар тогтоол, Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээ тогтоох 107-р тогтоол, МУ-ын БШУ-ны сайдын А/122 тушаал, МУЗГазрын 192 дугаар тогтоол, Сангийн сайдын 120 дугаар тушаал, МУЗГазрын 252 дугаар тогтоолыг тайлант онд мөрдөж ажилласан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна

Дотоод аудит, аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах /дотоод аудитораас шууд туслалцаа авах/ шаардлагагүйгэж үзлээ

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн

тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Ховд аймгийн Мөнххайрхан сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг *аккруэлмөнгөн* сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад *нийцсэн/нийцээгүй*, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт *тохирсон* байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Ховд аймгийн Мөнххайрхан сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна. Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 14.9 сая төгрөгөөр буюу 3.6 хувиар өссөн байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө		2140.7	2140.7
Авлага		665	665.0
Бараа материал	40726.5	52968.2	12241.7
Үндсэн хөрөнгө	372333.7	372262.9	0
<b>Нийт хөрөнгө</b>	413060.2	428036.8	<b>14976.6</b>
Өр төлбөр	1,968.20		-1968.2
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	411092	428036.8	16944.8
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>413,060.20</b>	<b>428,036.80</b>	<b>14976.6</b>

Дээрх хүснэгтээс харахад авлага 665,0, бараа материал 12241,7, Засгийн газрын хувь оролцоо данс 16944,8 мянган төгрөгөөр нэмэгдэж, өр төлбөр 1968,2 мянган төгрөгөөр тус тус буурсан үзүүлэлттэй байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 342.4 сая, нийт зарлагыг 342.4 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Төсвийн төслийн саналаас зардлыг 78.4 сая төгрөгөөр өсгөж баталсан байна. Энэ нь МУЗГ-ын 2022 оны 91 тоот тогтоолоор Хувьсах зардлын санхүүжилтийг хүүхэд өдрөөр хянаж, төсвийн санхүүжилтийг гүйцэтгэлээр нь тооцож, батлагдсан хуваарьт нийцүүлэн сар бүр сургалтын байгууллагад олгож байгаатай холбоотой байна.

Нэг хүүхдэд ногдох зардлын дундаж нормативаар олгох санхүүжилтийн гүйцэтгэлийг хүүхэд өдрөөр хянаж хагас, бүтэн жилээр тооцон, зохих өөрчлөлтийг тусган төсвийн ерөнхийлөн болон төвлөрүүлэн захирагчийн шийдвэрээр санхүүжүүлэх болсонтой холбоотой байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 95,7 сая төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр 342.4 сая төгрөгийг улсын төсвөөс олгосон байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 340,2 сая төгрөгийн санхүүжилт олгож, оны эцэст 2,1 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй гарсан байна. Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 340.2 сая төгрөг буюу 99.4 хувьтай байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл /мянган төгрөгөөр/*

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	71801/81605	800.0	800.0	-	100
2	71801/81807	36,299.1	36,299.1	-	100
3	71801/81816	1,179.0	1,179.0	-	100
4	71801/81823	800.0	800.0	-	100
5	71801/81834	218,692.3	216,551.6	2,140.68	99
6	71801/81835	37,187.6	37,187.6	-	100
7	71801/80111	32,083.0	32,083.0	-	100
8	71801/80112	15,352.4	15,352.4	-	100
	ДҮН	342,393.4	340,252.7	2,140.68	

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Нэмэлт төсөвтэй холбоотой ямар нэгэн гүйлгээ гараагүй болно.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 4 хөтөлбөрийн 68арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

*Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт*

/мянган төгрөгөөр/

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	Монгол хэл бичиг	2021-2024	Монгол хэлний хэрэглээ нэмэгдэнэ, эх хэлээ хайрлах дээдлэх үзэл төлөвшинө. Бүх	4 зорилтын хүрээнд 10 төрлийн ажил зохион байгуулсан. Биелэлтийн	үгүй	Улсын төсвөөс 70.000, багш ажилтнууд 90.000 төгрөг

			нийтийн монгол бичгийн мэдлэг дээшилнэ.	хувь 80.7		
2	Чадварлаг багш, оюутан, сурагч	2021-2024	Баруун бүсийн боловсролын салбарын тулгамдсан асуудлыг үе шаттай шийдвэрлэх гарч бий болсон байна, залуу багш нарын сайн дурын байгууллагын ажиллагаа идэвхжсэн байна.	8 зорилтын хүрээнд 30 төрлийн сургалт үйл ажиллагаанд оролцож, тодорхой ажлуудыг зохион байгуулсан Биелэлтийн хувь 80	Хичээл практикийн зардал: 3.030.0 төгрөг, Багшийн тасралтгүй хөгжлийг дэмжих зардал: 800.0 төгрөг, Нөхөн хангалтын зардал: -1.179.0 төгрөг, Эрүүл мэндийг дэмжих зардал – 800.0 төгрөг, Цахим хэрэглээний зардал – 800.0 нийт 6609000	Улсын төсвөөс:6609000
3	Тогтвортой хөгжлийн боловсрол	2021-2024	Хүүхэд багачууд багаасаа өөрийн онцлог сонирхол, ирээдүйн хөгжилд нийцсэн, ажил мэргэжлийн чиг баримжаатай суралцах боломж нэмэгдэнэ	3 зорилтын хүрээнд 8 ажил зохион байгуулсан Биелэлтийн хувь 89	үгүй	үгүй
4	Чанартай боловсрол	2021-2024	Мэдлэг ойлголт тасралтгүй эзэмшинэ.	4 зорилтын хүрээнд 12 төрлийн ажил зохион байгуулсан. Биелэлтийн хувь 85	үгүй	үгүй

#### 4. АУДИТЫН ТАЙЛАН

##### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Ховд аймгийн Мөнххайрхан сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах Үндсэн хөрөнгөтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Гэрэлт Хөхийн тэнцвэр Аудит ХХК-ны Ховд аймаг дахь салбарын захирал, аудитор Д.Хишгээ 2023 оны 1 дугаар сарын 23 -нээс 2023 оны 01 дугаар сарын 28 –ны хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа 2023 оны 01 дүгээр сарын 25 өдрийн А/1 албан бичгээр ирүүлсэн боловч 2023 оны 01 дугаар сарын 24-ны өдөр тайлангаа ирүүлсэн.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлого сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг Бага гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны 3-р улирлын нийт орлого 286,4 сая төгрөгөөс 2 хувиар буюу 5,7 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоолоо.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага хуулиар хориглосон зардлуудыг санхүүжүүлээгүй байна.

Мөнххайрхан сумын Хүүхдийн цэцэрлэгт нь энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан тэргүүн дэд, дэд, орлогч дарга, 7 дугаар зүйлд заасан албан тасалгаа, 10 дугаар зүйлд заасан цалин хөлс, нэмэгдэлтэй холбоотой заалтууд хамаарахгүй байна.

8 дугаар зүйлд заасан дүрэмт хувцастай холбоотой тус газраас зардал гараагүй

9 дүгээр зүйлд заасан албан томилолтын хувьд тус байгууллага нь 210,0 мянган төгрөгийн зардал гаргасан нь Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч аймгийн Боловсролын газраас зохион байгуулсан сургалтад суусан байна.

11 дүгээр зүйлд заасан нэг удаагийн мөнгөн тэтгэмж, 12 дугаар зүйлд заасан бусад хангамжийн хувьд холбоотой зардал, 13 дугаар зүйлд заасан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, 14 дүгээр зүйлд заасан цахим худалдан авалт, 15 дугаар зүйлд заасан хэмнэлтийн бусад арга хэмжээтэй холбоотой ямар нэгэн зардал гараагүй байна. Ямар нэгэн төсвийн зарцуулалттай холбоотой хэмнэлт бий гараагүй.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 119 мэдээллээс хугацаандаа оруулсан 117 мэдээлэл, хугацаа хоцроосон мэдээлэл 2 байна.

Шийдвэрлэсэн нь: Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

##### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

210302 халаалтын зардлаас 716.0 мянган төгрөгийн цалингийн зардал гаргасан, БҮБЗ-аас бензины үнэ 1286.7, хөрөнгө худалдан авахтай холбоотой 1857.0 хоолны зардал 1022.4, хичээл практикийн зардлаас 210.0 томилолт, 50.0 номны зардлууд тус тус зарцуулжээ.

Хангамжийн материалын зардлын төсвийг энэ онд бүгдийг бараа үйлчилгээний бусад зардал дансанд бүртгэж тайлагнасан нь Сангийн сайдын Зардлын эдийн засгийн ангилал батлах тухай 2021-10-29-ны 190 тоот тушаалтай нийцээгүй байна.

#### Шийдвэрлэсэн нь:

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгууртнийцээгүй гэж дүгнэлээ.

### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

#### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Тус сургуульд 2022 оны 11 сард Төрийн аудитын баг завсрын аудит хэрэгжүүлэхэд төсвийн зарцуулалтад тавих дотоод хяналт өмнөх онуудаас сайжирсан ололттой байна гэж дүгнэж зөрчил илрээгүй байна.

#### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

*Өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийн талаар бичнэ.*

*Хүснэгт 4Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт*

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	283.9	1	283.9	100
Албан шаардлага					
Зөвлөмж	1	33299.1	1	33299.1	100
Нийт дүн	2	33583	2	33583	100

### **4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй**

## **5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

Аудитаар нийт 24648.7 мянган төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрснээс 24648.7 мянган төгрөгийн зөвлөмж өгсөн.

#### **5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### **1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал**

#### **Илрүүлэлт:**

Тус цэцэрлэгийн үндсэн хөрөнгийн бүртгэлд ашиглах хугацаа дууссан 37 нэр төрлийн 16977.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө байгаа нь Төсвийн тухай хуулийн 14.2.3-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах"; 16.5.4-т "төсвийн

<sup>1</sup>Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх"; /Төсвийн төвлөрүүлэн захирагчид өгөх/, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31.1-т "Төрийн өмчит хуулийн этгээд эзэмшилдээ байгаа илүүдэл үндсэн эд хөрөнгө, түүнчлэн ашиглах хугацаа нь дууссан буюу эсхүл осол гэмтэлд өртсөний улмаас зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон бөгөөд засаж, сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тооцоогоор нотлогдсон эд хөрөнгийг худалдаж, шилжүүлж, акт тогтоон устгаж болно." зөрчсөн байна.

**Өгсөн зөвлөмж:** Өөрийн эзэмшилд байгаа илүүдэл үндсэн эд хөрөнгө, ашиглах хугацаа нь дууссан дээрх хөрөнгийг ашиглах боломжтой хөрөнгийг дахин үнэлж ашиглах, ашиглах боломжгүй хөрөнгийг актлаж устгаж эдийн засгийн хувьд үр ашигтай байхаар шийдвэрлэх

## 2 . Цалин хөлс ,нийгмийн даатгалын шимтгэлтэй холбоотой асуудал

### **Илрүүлэлт:**

2022 онд тус цэцэрлэг 235630.5 мянган төгрөгний цалингийн сан тайлагнасан бөгөөд хянахад нийт цалингийн 226422.3 мянган төгрөг байгаа бөгөөд 6935.5 мянган төгрөгний цалингийн санг дутуу тайлагнасан байгаа ньТөсвийн тухай хуулийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодо х бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-т "дансныөглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах *заалт зөрчсөн байна.*

### **Өгсөн зөвлөмж:**

Сар бүрийнхээ бодсон цалинг Нийгмийн даатгалын хэлтэст явуулсан тайлантай тулган зөрүү дүнгээр нийгмийн даатгалын нөхөн тайлан гаргах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийнаудитын байгууллагад 2023 оны 6 дугаар сарын 15 - ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### **Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

Алдааны товч утга	Нийт алдаа		Үүнээс	
	Тоо	Дүн	Залруулсан	
			Тоо	Дүн
Төсвийн гүйцэтгэлийн тайланд батлагдсан төлөвлөгөө орлого 24068.3, зарлагаа 8250.0 дутуу тайлагнасан бөгөөд гүйцэтгэлд орон нутгийн санхүүгийн дэмжлэгийн 12705.7 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан.	2	12,705.7	2	12705.7
Аймгийн ОНХсангаас барилгын дээврийн засвар хийгдсэн 20000.0 мянган төгрөгийг үр дүнгийн тайланд зарлагаар бүртгэж тайлангийн үеийн үр дүнг/-23055.2/ мянган төгрөгөөр илэрхийлсэн байна.	1	40,000.0	1	40000
Үр дүнгийн тайлан, Мөнгөн гүйлгээний тайланд цалинг 5276.0 дутуу, , НДШ -ийг 5293.0 мянган илүү тайлагнасан байна.	2.0	10,569.9	2.0	10,569.9
<b>Нийт алдааны дүн</b>	<b>5</b>	<b>63275.6</b>	<b>5</b>	<b>63275.6</b>

### **Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс	
	Тоо	Дүн	Зөвлөмж	
			Тоо	Дүн
2022 оны үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлийн тайланд 37 ш 16997204 төгрөгний тэг үлдэгдэлтэй үндсэн хөрөнгө байна.	1	16977.2	1	16977.2

2022 онд тус цэцэрлэг 235630.5 мянган төгрөгний ЦФ-той бөгөөд НДХ-т 230320.2 мянган төгрөгний ЦФ-тайлагнасан бөгөөд үүнээс 3780.0 мянган төгрөг ЦФ ЖАТ-ын, ажилчдын ЦФ 226422.3 мянган төгрөг /235630.5-226422.3/ зөрүү 9208.3 мянган төгрөгний ЦФ-ыг нийгмийн даатгалд тайлагнаагүй байна.	1.0	6935.5	1.0	6935.5
<b>Зөрчлийн дүн</b>	<b>2</b>	<b>23912.7</b>	<b>2</b>	<b>23912.7</b>

### Санхүүгийн тайлангийн аудитын нийцлийн зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс	
			Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил				
210302 халаалтын зардалаас 716.0 мянган төгрөгний цалингийн зардал гаргасан.	1	716.0	1	716.0

Энэ нь Хангамжийн материалын зардлын төсвийг энэ онд бүгдийг бараа үйлчилгээний бусад зардал дансанд бүртгэж тайлагнасан нь Сангийн сайдын Зардлын эдийн засгийн ангилал батлах тухай 2021-10-29-ны 190 тоот тушаалтай нийцээгүй байна.

#### Өгсөн зөвлөмж:

Сангийн сайдын 190 тоот тушаалыг мөрдөн ажиллаж эдийн засгийн ангилалыг үнэн зөв тайлагнах Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 6 дугаар сарын 15 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

##### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Үүнээс	
	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төсвийн гүйцэтгэлийн тайланд батлагдсан төлөвлөгөө орлого 24068.3, зарлагаа 8250.0 дутуу тайлагнасан бөгөөд гүйцэтгэлд орон нутгийн санхүүгийн дэмжлэгийн 12705.7 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан.	2	12,705.7	2	12705.7
Аймгийн ОНХсангаас барилгын дээрийн засвар хийгдсэн 20000.0 мянган төгрөгийг үр дүнгийн тайланд зарлагаар бүртгэж тайлангийн үеийн үр дүнг зөрүүтэй	1	40,000.0	1	40000
Үр дүнгийн тайлан, Мөнгөн гүйлгээний тайланд цалинг 5276.0 дутуу, НДШ -ийг 5293.0 мянган илүү тайлагнасан байна.	2.0	10,569.9	2.0	10,569.9
<b>Нийт алдааны дүн</b>	<b>5</b>	<b>63275.6</b>	<b>5</b>	<b>63275.6</b>

##### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс	
	Тоо	Дүн	Тоо	Дүн
2022 оны үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлийн тайланд 37 ш 16997204 төгрөгний тэг үлдэгдэлтэй үндсэн хөрөнгө байна.	1	16997.2	1	16997.2
2022 онд тус цэцэрлэг нийгмийн даатгалд 6935,5 мянган төгрөгний цалингийн сан дутуу тайлагнасан	1.0	6,935.5	1.0	6,935.5
210302 халаалтын зардалаас 716.0 мянган төгрөгний цалингийн зардал гаргасан.	1	716.0	1	716.0
<b>Нийт дүн</b>	<b>3</b>	<b>24648.7</b>	<b>3</b>	<b>24648.7</b>

#### АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  А.ЦЭЦЭГСҮРЭН

АУДИТЫН МЕНЕЖЕР:  Д.ХИШГЭЭ

ТАЙЛАНГ БИЧСЭН:

АУДИТОР:  Д.ХИШГЭЭ

#### АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Х.БОЛДБААТАР

АУДИТЫН МЕНЕЖЕР: А.ЦЭЦЭГСҮРЭН

#### ТАЙЛАНГ БИЧСЭН:

АУДИТОР: Д.ХИШГЭЭ

